

<p>ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/</p> <p>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ</p>	<p>Law on Higher Education /Renewed composition/</p> <p>CHAPTER ONE GENERAL PROVISION</p>
<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p>	<p>Article 1. Purpose of the Law</p>
<p>1.1.Энэ хуулийн зорилт нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгаа, санхүүжилт, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.</p>	<p>1.1. Governing higher education management, organization, training, research, funding, and related relations is the purpose of this law.</p>
<p>2 дугаар зүйл. Дээд боловсролын зорилго</p>	<p>Article 2. Purpose of the Higher Education</p>
<p>2.1.Дээд боловсролын зорилго нь нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах, дэвшилтэт шинэ санаа, судалгаа, инновацыг хөгжүүлэх, бүтээлчээр ашиглах, олон соёлын орчинд ажиллаж, амьдрах чадвартай, ёс суртахуунтай иргэнийг бэлтгэхэд оршино.</p>	<p>2.1. Higher education's purpose is to contribute to social and economic progress, to generate and creatively use advanced ideas, research, and innovation, and to produce moral citizens capable of working and living in a multicultural environment.</p>
<p>3 дугаар зүйл. Дээд боловсролын хууль тогтоомж</p>	<p>Article 3. Legislation of Higher Education</p>
<p>3.1.Дээд боловсролын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын ерөнхий хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.</p> <p>3.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.</p>	<p>3.1.The Mongolian Constitution, Law on General Education, this law, and other legislative actions adopted in compliance with these laws comprise higher education legislation.</p> <p>3.2. In terms of Mongolia's international agreements specifying otherwise than this law, the provisions of the international agreements shall be followed.</p>
<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p>	<p>Article 4. Definition of Legal Terms</p>
<p>4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:</p> <p>4.1.1."ахисан түвшний сургалт" гэж магистрын болон докторын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг;</p>	<p>4.1. The following terms shall have the following meanings in this law:</p> <p>4.1.1. "Advanced study program" refers to activities related to master's and doctoral programs.</p>

<p>4.1.2."дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагч" /цаашид "суралцагч" гэх/ гэж дэд бакалаврын болон бакалаврын хөтөлбөрөөр суралцагч оюутан, магистрын хөтөлбөрөөр суралцагч магистрант, докторын хөтөлбөрөөр суралцагч докторантыг;</p> <p>4.1.3."судалгааны грант" гэж Инновацийн тухай хуулийн 3.1.7-д зааснаас гадна байгууллага, судлаачийн судалгааны ажилд зориулж иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагаас урьдчилан нөхцөл, болзолтой буцалтгүй олгох мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийг;</p> <p>4.1.4."судалгааны их сургууль" гэж судалгааны үйл ажиллагаа эрхэлдэг, бакалавр болон ахисан түвшний сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллагыг;</p> <p>4.1.5."суралцагчийн тэтгэлэг" гэж сургалтын төлбөр, судалгааны болон амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу тодорхой хэсгийг санхүүжүүлэхэд зориулан суралцагчид олгох мөнгөн тусламжийг;</p> <p>4.1.6."сургалтын зээл" гэж сургалтын төлбөр, амьжиргааны зардлыг бүхэлд нь буюу зарим хэсгийг санхүүжүүлэхэд зориулан эргэн төлөгдөх хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцагчид олгох мөнгөн хөрөнгийг;</p> <p>4.1.7."сургалтын төлбөрийн хөнгөлөлт" гэж дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн сурлагын амжилт, төлбөрийн чадамжийг тооцож төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;</p> <p>4.1.8."шаталсан сургалт" гэж боловсролын бусад түвшний хөтөлбөрийг зэрэгцсэн болон дараалсан байдлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг.</p>	<p>4.1.2. "A student of a higher education educational institution" (hence referred to as "student") refers to a student enrolled in an associate bachelor's or bachelor's program, a master's student enrolled in a master's program, or a doctoral student enrolled in a doctoral program.</p> <p>4.1.3. In addition to those stated in Article 3.1.7 of the Law on Innovation, the term "research grant" refers to monetary and non-monetary funding granted by citizens, legal entities, and international organizations for the research work of organizations and researchers.</p> <p>4.1.4. "Research university" refers to a higher education institution that conducts undergraduate and advanced study programs as well as conducts research.</p> <p>4.1.5. "Student scholarship" refers to financial aid provided to a student to cover all or a portion of tuition, research, and living expenses;</p> <p>4.1.6. "Educational loan" refers to monetary funds supplied to a student on favorable terms to support all or a portion of tuition and living expenses;</p> <p>4.1.7. "Tuition fee discount" refers to a percentage exemption from fees depending on a student's academic performance and ability to pay at a higher education institution;</p> <p>4.1.8. "Hierarchical training" refers to the concurrent or sequential deployment of programs at several levels of education.</p>
---	---

<p>5 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаандаа баримтлах зарчим</p>	<p>Article 5. Principles to be followed by higher education institutions in their operations</p>
<p>5.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь үйл ажиллагаандаа Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:</p> <p>5.1.1. эрдмийн эрх чөлөөг эрхэмлэх;</p> <p>5.1.2. оюуны бүтээл, судалгааны ёс зүйг дээдлэх;</p> <p>5.1.3. дээд боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг дэмжсэн байх;</p> <p>5.1.4. хамтын удирдлагатай, улс төр, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.</p>	<p>5.1. In addition to the Law on General Education, higher education institutions shall follow the following principles in their operations;</p> <p>5.1.1. Honoring academic freedom;</p> <p>5.1.2. Honoring the ethics of intellectual invention and research;</p> <p>5.1.3. To support the independence of higher education institutions;</p> <p>5.1.4. To be collaboratively administered and free from politics and conflicts of interest;</p>
<p>ХОЁРДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</p>	<p>CHAPTER TWO HIGHER EDUCATION INSTITUTIONS, AND THEIR ORGANIZATIONS</p>
<p>6 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллага</p>	<p>Article 6. Higher education institutions</p>
<p>6.1. Дээд боловсролын сургалтын байгууллага нь коллеж, дээд сургууль, их сургууль байна.</p> <p>6.2. "Монгол Улсын" болон "Үндэсний" гэсэн үг, түүний англи хэл дээрх орчуулга, барааны тэмдгийг зөвхөн төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад хэрэглэнэ.</p> <p>6.3. Энэ хуулийн 6.1, 7.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг техникийн зохицуулалтад үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.</p> <p>6.4. Цэрэг, цагдаагийн мэргэжлийн чиглэлийн сургалтын үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 3.1.18-д заасан төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага эрхэлнэ.</p>	<p>6.1. Colleges, institutes, and universities are higher education institutions;</p> <p>6.2. The words "Mongolia" and "National," as well as their English translations and trademarks, are exclusively used in state-owned higher education institutions;</p> <p>6.3. The member of the government in charge of education shall determine the categorization of higher education institutions stated in Articles 6.1 and 7.4 of this law based on technical regulations;</p> <p>6.4. Military and police training operations shall be charged by the state-owned higher education institutions stated in Article 3.1.18 of the General Law on Education.</p>

<p>6.5. Энэ хуулийн 6.1, 7.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагад тавих техникийн зохицуулалтыг Засгийн газар батална.</p> <p>6.6. Консерватор нь ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсрол эзэмшүүлэх шаталсан сургалттай хөгжмийн дээд боловсролын сургалтын байгууллага байна.</p>	<p>6.5. The technical regulations for higher education institutions stated in Articles 6.1 and 7.4 of this law shall be approved by the government.</p> <p>6.6. The Conservatory is a music higher education institution that offers courses in general education, professional education, technical education, and higher education in a hierarchical system;</p>
<p>6.7. Технологийн коллеж нь бүрэн дунд боловсрол, техникийн болон дээд боловсролын шаталсан сургалттай, дэд бакалавр, бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг дээд боловсролын сургалтын байгууллага байна.</p>	<p>6.7. The College of Technology is a higher education educational institution that provides secondary education, technical, and higher education courses, as well as associate and bachelor's degree programs.</p>
<p>7 дугаар зүйл. Их сургууль</p>	<p>Article 7. University</p>
<p>7.1. Их сургууль нь дэд бакалавр, бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгаа, туршилт-үйлдвэрлэлийн байгууллага байна.</p> <p>7.2. Их сургууль нь ахисан түвшний сургалт дагнан эрхэлж болно.</p> <p>7.3. Их сургууль нь харьяалалдаа коллеж, технологийн коллеж, политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, судалгааны лаборатори, төв, хүрээлэн, ахлах сургууль, дадлагын баазтай байж болно.</p> <p>7.4. Их сургуулийг үйл ажиллагааны хүрээ, сургалт, судалгааны чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагч, төгсөгчийн тоо, холбогдох бусад үзүүлэлтэд үндэслэн судалгааны, сургалтын, мэргэжлийн гэж ангилна.</p> <p>7.5. Их сургууль нь сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор байж болно.</p>	<p>7.1. The university is a training, research, and experimental-production institution that offers educational programs leading to associate, bachelor's, master's, and doctorate degrees.</p> <p>7.2. The university may provide an advanced study program.</p> <p>7.3. A university may have colleges, technical colleges, polytechnic institutions, vocational training schools, research laboratories, centers, institutes, high schools, and training camps under its control.</p> <p>7.4. Based on the scope of activities, training, research fields, curriculum, number of students and graduates, and other relevant indicators, the university will be categorized as research, training, or professional.</p> <p>7.5. A university can be complex for training, research, and production.</p>

<p>7.6 .Багш бэлтгэх их сургууль нь харьяалалдаа цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.</p> <p>7.7.Соёл, урлаг, цэргийн мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь бүрэн дунд сургуультай /6-12 дугаар анги/ байж болно.</p> <p>7.8.Судалгааны их сургуулийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хуулиар байгуулна.</p>	<p>7.6. Kindergartens and secondary schools may be under the administration of a teacher training university.</p> <p>7.7. A university with a full secondary school (grades 6-12) may conduct educational activities in the disciplines of culture, art, and military professions.</p> <p>7.8. Following the submission of the Government, the research university shall be formed by a law of the Parliament of Mongolia.</p>
<p>8 дугаар зүйл. Дээд сургууль</p>	<p>Article 8. The Institute</p>
<p>8.1.Дээд сургууль нь сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулж, дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт, судалгааны байгууллага байна.</p> <p>8.2.Дээд сургууль нь харьяалалдаа коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.</p>	<p>8.1. The Institute is a training and research organization that undertakes teaching, research, and research activities and offers associate, bachelor's, and master's degrees.</p> <p>8.2. The Institute may have a college, vocational training school, and high school under its administration.</p>
<p>9 дүгээр зүйл.Коллеж</p>	<p>Article 9. The College</p>
<p>9.1.Коллеж нь дэд бакалавр, бакалавр, магистрын зэрэг олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлдэг сургалт-судалгаа, сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.</p> <p>9.2.Коллеж нь харьяалалдаа политехник коллеж, мэргэжлийн боловсролын сургууль, ахлах сургуультай байж болно.</p>	<p>9.1. The college is a training-research-production institution that offers educational programs leading to associate, bachelor's, and master's degrees.</p> <p>9.2. The college may have a polytechnical college, vocational training school, and high school under its administration.</p>
<p>10 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах</p>	<p>Article 10. Establishment, alteration, and dissolution of a Higher education institution</p>
<p>10.1.Дээд боловсролын сургалтын байгууллагыг Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу байгуулж зөвшөөрөл олгоно.</p> <p>10.2.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.</p>	<p>10.1. Higher education institutions shall be formed and licensed in compliance with the General Law on Education.</p> <p>10.2. The Government shall make decisions on the establishment, alteration, and dismissal of state and locally-owned education institutions.</p>

<p>10.3.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр харьяаллын сургууль байгуулна.</p> <p>10.4.Дээд боловсролын сургалтын байгууллага татан буугдсан нөхцөлд суралцагчийг ижил мэргэжлийн сургуульд шилжүүлэн суралцуулах асуудлыг тухайн сургалтын байгууллагын эцсийн эзэмшигч буюу үүсгэн байгуулагч, Удирдах зөвлөл нь дээд боловсролын бусад байгууллагатай хамтран шийдвэрлэнэ.</p> <p>10.5.Энэ хуулийн 10.4-т заасантай холбогдон гарах зардлыг татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллагын үүсгэн байгуулагч, эцсийн эзэмшигч нь хариуцна.</p> <p>10.6.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага үйл ажиллагаа явуулах хугацаандаа баталсан шийдвэр, суралцагчийн хувийн хэрэг, мэдээлэл, төгсөгчийн дипломын хуулбар, сургалтын төлөвлөгөө зэрэг дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаатай холбогдох баримт бичгийг татан буугдах шийдвэр гарснаас хойш 6 сарын дотор Үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.</p> <p>10.7.Татан буугдсан дээд боловсролын сургалтын байгууллага төгсөлт хийгээгүй суралцагчийг өөр сургуульд шилжүүлэхдээ түүнийг сургуульд анх элсүүлсэн шийдвэр, судалсан багц цаг, сурлагын дүн, шалгалттай холбоотой материалыг шилжүүлсэн шийдвэрийн хамт шилжин суралцах сургуулийн захиргаанд хүлээлгэн өгнө.</p>	<p>10.3. With the agreement of the central state administrative authority in charge of education, a non-state-owned higher education educational institution shall establish an affiliated secondary school.</p> <p>10.4. In terms of the dissolution of a higher education educational institution, the final ultimate owner or founder of the educational institution, along with the Board of Governors and other higher education institutions, shall decide on the transfer of the student to the same professional school.</p> <p>10.5. The costs paid in connection with the provisions of Article 10.4 of this law shall be the responsibility of the founder and ultimate owner of the dissolved higher education institution.</p> <p>10.6. Documents regarding the activities of the higher education educational institution, such as decisions made during the operation of the dissolved higher education educational institution, personal files and information of students, copies of graduate diplomas, study plans, and so on, shall be submitted to the National Central Archives within 6 months of the decision to dissolve the higher education educational institution.</p> <p>10.7. When transferring a student who has not completed his studies to another higher educational institution, he shall inform the administration of the transferring educational institution of the decision on his first enrollment, the number of hours attended, learning results, and examination materials.</p>
<p>11 дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц</p>	<p>Article 11. The organizational structure of the Higher educational institution</p>

<p>11.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна.</p> <p>11.2.Их, дээд сургуульд Эрдмийн зөвлөл, Хөтөлбөрийн хороо, коллежид Сургалт, арга зүйн зөвлөл ажиллана.</p> <p>11.3.Эрдмийн зөвлөл болон Хөтөлбөрийн хороо, Сургалт, арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг тухайн сургуулийн гүйцэтгэх удирдлага батална.</p> <p>11.4.Анагаах ухааны чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг их сургууль нь их сургуулийн эмнэлэгтэй байна.</p> <p>11.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын харьяаллын сургууль нь хуулийн этгээд байх бөгөөд бие дааж магадлан итгэмжлэлд орно.</p> <p>11.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр орон нутагт салбар сургууль байгуулж болно.</p> <p>11.7.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон бусад холбогдох байгууллагын хамтарсан шийдвэрээр аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт, эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэл, дадлагын түшиц газар болгож болно.</p> <p>11.8.Дээд боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтцийн үндсэн болон бусад нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг тухайн сургалтын байгууллагын дүрмээр тогтооно.</p> <p>11.9. Дээд боловсролын сургалтын байгууллага нь дотуур байртай байж болно. Дотуур байранд тавих шаардлагыг</p>	<p>11.1. Departments and laboratories are the primary organizational components of higher education institutions.</p> <p>11.2. Universities and institutes shall have an Academic Senate, a Program Committee, and a Teaching and Methodology Council.</p> <p>11.3. The Academic Senate, the Program Committee, and the Teaching and Methodology Council shall have their composition and working processes approved by the university's executive administration.</p> <p>11.4. The university, which conducts educational activities in the field of medicine, may have a university hospital.</p> <p>11.5. The affiliated secondary school of the higher education educational institution shall be a legal entity and shall be accredited independently.</p> <p>11.6. With the approval of the central state administrative in charge of education, a higher education institution may establish a branch secondary school in a province.</p> <p>11.7. Enterprises and organizations can be designated as a basis for training, research, experimental production, and practice by a joint decision of the central state administrative organization in charge of education and other connected organizations.</p> <p>11.8. The rights, duties, and obligations of the main and other units of the organizational structure of the higher education institution shall be determined by the statute of the educational institution.</p> <p>11.9. The higher education may have a dormitory. Requirements for the dormitory shall be determined by the standard technical regulation.</p>
---	--

<p>стандарт, техникийн зохицуулалтаар тогтооно.</p> <p>11.10. Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах дүгнэлт, санал гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хөтөлбөрийн хороотой байна.</p> <p>11.11. Энэ хуулийн 11.4-т заасан их сургуулийн эмнэлэг нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж болно.</p> <p>11.12. Энэ хуулийн 6.4-т заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь цэрэг, цагдаагийн тогтолцоонд хамаарах анги, байгууллага, цэргийн байртай байна.</p> <p>12 дугаар зүйл. Дээд боловсролын чанарын баталгаажуулалт</p> <p>12.1. Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь сургуулийн сургалт, судалгааны гүйцэтгэлийн болон чанарын удирдлагыг сайжруулах зорилготой, нээлттэй, оролцогч талыг хамарсан тасралтгүй үйл ажиллагаа байна.</p> <p>12.2. Дээд боловсролын чанарын баталгаажуулалт нь дараах хэлбэртэй байна:</p> <p>12.2.1. Дотоод чанарын баталгаажуулалт;</p> <p>12.2.2. Хөндлөнгийн үнэлгээ;</p> <p>12.2.3. Магадлан итгэмжлэл;</p> <p>12.3. Дээд боловсролын сургалтын байгууллага нь өөрийн үнэлгээ, дотоод хяналт, хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх замаар дотоод чанарын баталгаажуулалтыг хийнэ.</p>	<p>11.10. The higher education institution shall have a part-time Program Committee tasked with planning, assessing, and making recommendations for curricular reform.</p> <p>11.11. The university hospital may engage in health care, services, training, and research activities under Article 11.4 of this law.</p> <p>11.12. The higher education educational institution stated in Article 6.4 of this law shall have units, organizations, and military buildings belonging to the military and police systems.</p> <p>Article 12. Quality Assurance of Higher Education</p> <p>12.1. Quality assurance in higher education is an ongoing, transparent, and interactive activity aimed at enhancing the performance and quality management of a university's teaching and research.</p> <p>12.2. Quality assurance of higher education shall have the following formation:</p> <p>12.2.1. Internal quality assurance;</p> <p>12.2.2. External assessment;</p> <p>12.2.3. Accreditation;</p> <p>12.3. Internal quality assurance shall be carried out by the higher education institution regularly through self-assessment, internal control, monitoring, and evaluation activities.</p>
--	--

<p>12.4. Хөндлөнгийн үнэлгээг Удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, төр, эцэг эх, оюутан, хамтран ажиллагч түнш зэрэг дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцогч талын хүсэлтээр үндэсний, эсхүл олон улсын мэргэжлийн байгууллага, мэргэжлийн холбоо, төлөөллийн бусад байгууллага болон шинжээч олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн арга, аргачлалын дагуу хийнэ.</p> <p>12.5. Магадлан итгэмжлэл нь дээд боловсролын сургалтын байгууллага болон хөтөлбөрийн чанарт эрх бүхий байгууллага мэргэжлийн, хараат бус үнэлгээ хийх үйл явц байна.</p> <p>12.6. Дээд боловсролын сургалтын байгууллага, Боловсролын ерөнхий хуулийн 12.5, энэ хуулийн 12.11-д заасан хөтөлбөр, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг 5 жил тутам магадлан итгэмжилнэ.</p> <p>12.7. Хуульд өөрөөр заагаагүй бол дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалтын хөтөлбөрийн чанар, нийцлийг сайжруулах зорилгоор Боловсролын ерөнхий хуулийн 12.5, энэ хуулийн 12.6-д зааснаас бусад тохиолдолд сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлүүлж болно.</p> <p>12.8. Шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө тухайн хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ.</p> <p>12.9. Дээд боловсролын сургалтын байгууллагын үндэсний эрэмбэ, чансаа, хөтөлбөрийн чанарыг энэ хуулийн 12.13-т заасан цахим сангийн мэдээлэлд үндэслэн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагатай хамтран 2 жил тутам тогтоон олон нийтэд мэдээлнэ.</p> <p>12.10. Энэ хуулийн 12.2-т заасан хөндлөнгийн үнэлгээ зохион байгуулах</p>	<p>12.4. External examination will be carried out at the request of stakeholders in higher education institutions such as the Board of Governors, executive management, government, parents, students, and cooperating partners by national or international professional organizations, professional associations, other representative organizations, and internationally recognized experts.</p> <p>12.5. Accreditation is a procedure that assesses the quality of higher education institutions and programs professionally and independently.</p> <p>12.6. Every five years, higher education institutions, programs stated in 12.5 of the General Law on Education and 12.11 of this law, and leading and in-demand professional training programs shall be accredited.</p> <p>12.7. Except as stated in Article 12.5 of the General Education Law and Article 12.6 of this Law, a higher education institution may be accredited voluntarily to improve the quality and consistency of the curriculum.</p> <p>12.8. Before beginning training in a new program, pre-accreditation shall be required.</p> <p>12.9. Every two years, the national ranking, ranking, and quality of programs at higher education institutions shall be determined and reported to the public in collaboration with internationally recognized evaluation organizations using information from the electronic database stated in Article 12.13 of this law.</p> <p>12.10. The member of the government in charge of education shall approve the</p>
---	---

<p>журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>12.11. Анагаах ухааны мэргэжлийн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг заавал магадлан итгэмжилнэ.</p> <p>12.12. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, дээд боловсролын сургалтын байгууллагын эрэмбэ, чансааны үзүүлэлт тухайн байгууллагын суралцагчид хуульд заасан дэмжлэг, зээл, тэтгэлэг олгох үндэслэл болно.</p> <p>12.13. Дээд боловсролын цахим мэдээллийн сан нь Боловсролын ерөнхий хуулийн 43.3-т зааснаас гадна магадлан итгэмжлэл, эрдэм шинжилгээний бүтээл, санхүүжилт, иргэний гадаад улсад эзэмшсэн боловсрол, үнэлгээ, хөдөлмөр эрхлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.</p> <p>12.14. Энэ хуулийн 12.6-д заасан хугацаагаар гурван удаа магадлан итгэмжлэл хийлгэсэн дээд боловсролын сургалтын байгууллага цаашид 10 жил тутам магадлан итгэмжлэл хийлгэнэ.</p>	<p>procedure for organizing the external evaluation specified in Article 12.2 of this law.</p> <p>12.11. Medical professional training programs must be accredited.</p> <p>12.12. The program's accreditation, ranking, and ranking of the higher education institution will serve as the foundation for giving support, loans, and scholarships to the institution's students.</p> <p>12.13. In addition to Article 43.3 of the General Law on Education, the electronic database of higher education contains information such as accreditation, academic works, funding, foreign education, assessment, and employment.</p> <p>12.14. A higher education institution that has been accredited three times within the period stated in Article 12.6 of this law shall be accredited every ten years.</p>
<p>ГУРАВДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХАРИЛЦААНД ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ, НИЙГМИЙН БАТАЛГАА</p>	<p>CHAPTER 3 PARTICIPANTS' RIGHTS, RESPONSIBILITIES, AND SOCIAL GUARANTEE IN HIGHER EDUCATION RELATIONS</p>
<p>13 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн эрх, үүрэг</p> <p>13.1. Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй:</p> <p>13.1.1. судалгааны ажилд оролцох, бусад сургуулийн суралцагч, багштай хамтран судалгаа хийх;</p> <p>13.1.2. Бүтээлээ хэвлүүлэх;</p>	<p>Article 13. Rights and Responsibilities of Students of Higher Education Institutions</p> <p>13.1. The rights of the Student, in addition to the rights of the Law on General Education:</p> <p>13.1.1. Participate in research works, and conduct research with students and professors from different universities;</p> <p>13.1.2. Publish a paper;</p>

<p>13.1.3. докторантаар суралцах хугацаандаа бакалаврын хөтөлбөрөөр суралцагчдад хичээл заах;</p> <p>13.1.4. дадлага хийх;</p> <p>13.1.5. инновац, шинэ мэдлэгийг хөгжүүлэх;</p> <p>13.1.6. хичээлийн хөтөлбөр болон багшийг сонгох;</p> <p>13.1.7. улиралд судлах багц цагийг сонгож, суралцах хугацааг төлөвлөх;</p> <p>13.1.8. ижил түвшний бусад сургуулийн хичээл болон багшийг сонгон суралцах, багц цагийг дүйцүүлэх;</p> <p>13.1.9. хуульд заасан бусад.</p> <p>13.2. Суралцагч нь дараах үүрэгтэй:</p> <p>13.2.1. хөтөлбөрийн агуулгыг бүрэн эзэмших, бие даан суралцах;</p> <p>13.2.2. сургуулийн дотоод дүрэм, журмыг мөрдөх;</p> <p>13.2.3. сургалтын төлбөрийг гэрээний дагуу төлөх;</p> <p>13.2.4. хуульд заасан бусад.</p>	<p>13.1.3. Teach undergraduate students during doctoral studies;</p> <p>13.1.4. Intern;</p> <p>13.1.5. Develop innovation and new knowledge;</p> <p>13.1.6. Select modules and the lecturer;</p> <p>13.1.7. 13.1.7. Choose a set of credit hours for the semester and arrange the study period;</p> <p>13.1.8. Select modules and lecturers from other universities of the same level, and compare credit hours;</p> <p>13.1.9. Other rights as stated by law.</p> <p>13.2. Student responsibilities:</p> <p>13.2.1. Fully master the content of the curriculum, to study independently;</p> <p>13.2.2. Follow the internal regulations of the university;</p> <p>13.2.3. Pay tuition fees according to the contract;</p> <p>13.2.4. Other obligations as stated.</p>
<p>14 дүгээр зүйл. Суралцагчийн нийгмийн баталгаа</p> <p>14.1. Суралцагч нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах нийгмийн баталгаагаар хангагдана:</p> <p>14.1.1. стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан хичээлийн байр, лаборатори, номын сан, нийтийн хоол, биеийн тамирын заал, талбайгаар үйлчлүүлэх;</p>	<p>Article 14. Social welfare of students</p> <p>14.1. Students shall be provided with the following social guarantees in addition to the law on the General education:</p> <p>14.1.1. Use classrooms, labs, libraries, cafeterias, gymnasiums, and fields that meet standard, sanitary, and safety criteria;</p>

<p>14.1.2.сургалтын зээл авах;</p> <p>14.1.3.суралцагчийн тэтгэлэгт хамрагдах;</p> <p>14.1.4.хууль тогтоомжид заасан сургалтын төлбөрийн хөнгөлөлт эдлэх;</p> <p>14.1.5.хуульд заасан бусад.</p>	<p>14.1.2. Obtain study loan;</p> <p>14.1.3. Apply for student scholarship;</p> <p>14.1.4. Obtain tuition fee discounts as stated by law;</p> <p>14.1.5. Other benefits as stated by law.</p>
<p>15 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш</p> <p>15.1.Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багш нь докторын зэрэгтэй байна.</p> <p>15.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байна.</p> <p>15.3.Дээд боловсролын сургалтын байгууллагад семинар, дадлага, лабораторийн хичээлийг тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн, зөвлөх, дадлага, туршлагатай мэргэжилтэн удирдаж болно.</p> <p>15.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багшийн зэрэглэлтэй байна.</p> <p>15.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь тухайн сургалтын байгууллагын багшийн мэргэжлийн хөгжлийг хангах журмыг баталж, хэрэгжүүлнэ.</p>	<p>Article 15. Lecturer of a higher education educational institution</p> <p>15.1. The lecturer in charge of implementing the advanced study program shall have a PhD degree.</p> <p>15.2. The lecturer of a higher education educational institution shall have a degree of master or higher.</p> <p>15.3. A consultant, practitioner, or experienced specialist in the topic of study may lead seminars, internships, and laboratory sessions in higher education institutions.</p> <p>15.4. Lecturers in higher education institutions shall have the degrees of professor, associate professor, senior lecturer, lecturer, and trainee lecturer.</p> <p>15.5 The higher education institution shall approve and implement a procedure to ensure the professional development of its lecturers.</p>
<p>16 дугаар зүйл.Багшийн эрх, үүрэг</p> <p>16.1.Багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах эрхтэй:</p> <p>16.1.1.эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл авах;</p> <p>16.1.2.бүтээлийн чөлөө авах;</p>	<p>Article 16. Rights and Duties of Lecturer</p> <p>16.1. Rights of the lecturer in addition to law on Genel education:</p> <p>16.1.1. Receive an academic degree and increments;</p> <p>16.1.2. Receive a research leave;</p>

<p>16.1.3.зөвлөх үйлчилгээ үзүүлэх;</p> <p>16.1.4.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүн, технологи, инновацын бүтээгдэхүүн, оюуны өмчөө хамгаалуулах, эдийн засгийн эргэлтэд оруулах.</p> <p>16.2.Багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах үүрэгтэй:</p> <p>16.2.1.мэргэжлээрээ нийгэмд үйлчлэх, соён гэгээрүүлэх, сурталчлах ажилд оролцох;</p> <p>16.2.2.байгууллагын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр чанарын баталгаажуулалт, сургалтын хөтөлбөрийн сайжруулалтад оролцох;</p> <p>16.2.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх.</p>	<p>16.1.3. Provide consulting services;</p> <p>16.1.4. Protect results of scientific analysis and research, technologies, innovative products, and copyright, as well as their introduction into economic circulation.</p> <p>16.2 Duties of the lecturer in addition to the General Law on Education:</p> <p>16.2.1. Engage in the profession of serving, enlightening, and improving society;</p> <p>16.2.2. Participate in quality assurance and contribute to updating a course curriculum as part of the organization's core operations:</p> <p>16.2.3. Conduct research and research work.</p>
<p>17 дугаар зүйл.Багшийн нийгмийн баталгаа</p> <p>17.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш нь дараах нийгмийн баталгаагаар хангагдана:</p> <p>17.1.1.өөрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд байгуулагдсан гарааны компанийн инновацын бүтээгдэхүүн, үйлчилгээний орлогоос хувь, ногдол ашиг хүртэх;</p> <p>17.1.2.мэргэжил, ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг авах;</p> <p>17.1.3.судалгаа, эрдэм шинжилгээний ажил хийх боломж, орчин, нөхцөлөөр хангагдах.</p> <p>17.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тухайн ажиллаж байгаа байгууллагаас дараах дэмжлэгийг үзүүлж болно:</p>	<p>Article 17. Social Guarantee of Lecturers</p> <p>17.1.The following social guarantees shall be provided to lecturers at higher education educational institutions:</p> <p>17.1.1. to obtain a proportion or dividend from the income of the start-up developed as a result of their academic and research activities</p> <p>17.1.2. receive support in enhancing their professional abilities;</p> <p>17.1.3. to be provided with the opportunity, environment, and conditions for performing research and academic activity.</p> <p>17.2. Lecturers at higher education institutions may receive the following support from the institution where they work:</p>

<p>17.2.1.орон нутаг дахь төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилтанд орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийг 5 жил тутамд нэг удаа олгох;</p> <p>17.2.2.дээд боловсролын сургалтын байгууллагын харьяа мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багшид Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16.1.2-т заасан тэтгэмж олгох.</p> <p>17.3.Энэ хуулийн 17.2.1, 17.2.2-т заасан дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны нийгмийн баталгааг хангахтай холбогдсон харилцааг тухайн сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулна.</p>	<p>17.2.1. to grant an increment for steady employment in the locality to lecturers and employees working in state-owned higher education institutions in the locality once every five years;</p> <p>17.2.2. to grant lecturers of vocational training schools and polytechnic colleges affiliated with higher education institutions the increments stated in Article 16.1.2 of the Law on Vocational and Technical Education and Training.</p> <p>17.3. The relations relating to the provision of social security for lecturers and employees of higher education I institutions stated in Articles 17.2.1 and 17.2.2 of this law are regulated by the educational institution's internal regulations.</p>
<p>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР, АГУУЛГА</p> <p>18 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын элсэлт</p> <p>18.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт бүрэн дунд боловсрол эзэмшсэн, элсэлтийн шаардлага хангасан хүнийг элсүүлнэ.</p> <p>18.2.Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд энэ хуулийн 18.1 дэх хэсэг хамаарахгүй.</p> <p>18.3.Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22, энэ хуулийн 18.8-д заасан үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах</p>	<p>CHAPTER FOUR HIGHER EDUCATION CURRICULUM AND CONTENT</p> <p>Article 18. Higher education educational institution's admission</p> <p>18.1. An individual who has completed secondary education and meets the admission standards shall be admitted to higher education institutions' associate bachelor's and bachelor's programs.</p> <p>18.2. Part 18.1 of this law does not apply to the admission of a graduate of a polytechnic college or a higher education institution with hierarchical training to an associate bachelor's or bachelor's program in the appropriate field.</p> <p>18.3. The member of the Government in charge of education shall approve the procedure for organizing assessment</p>

<p>журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>18.4.Дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэгчийн элсэлтийн шалгалтын босго оноог өмчийн хэлбэр харгалзахгүйгээр боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ижил хэмжээгээр тогтооно.</p> <p>18.5.Элсэлтийн шалгалтын босго оноог шинэчлэхэд өмнөх босго оноог бууруулахгүйгээр тогтооно.</p> <p>18.6.Дээд боловсролын сургалтын байгууллага мэргэжил эзэмшихэд шаардагдах мэдлэг, ур чадварыг харгалзан элсэлтийн нэмэлт шалгалт зохион байгуулж болно.</p> <p>18.7.Ахисан түвшний сургалтад элсэгч, суралцагчид тавих шаардлага, элсэлтийн шалгалтыг сургуулийн дотоод журмаар зохицуулна.</p> <p>18.8.Элсэлтийн шалгалтын зохион байгуулалт, үнэлгээний арга зүйг олон улсын чиг хандлагад нийцүүлнэ.</p>	<p>and admission examinations stated in 26.1.22 of the General Education law and 18.8 of this law.</p> <p>18.4 Regardless of the form of ownership, the member of the government in charge of education shall set the threshold score for the entrance exam of applicants for associate bachelor's and bachelor's programs.</p> <p>18.5 When revising the entrance exam threshold, the prior threshold shall be retained without being reduced.</p> <p>18.6. Higher education institutions may organize supplementary admission examinations to assess the knowledge and abilities required to enter a profession.</p> <p>18.7. The requirements for applicants and students for advanced study programs and entrance exams shall be regulated by the university's internal procedure.</p> <p>18.8. The structure and evaluation methodology of the entrance examination shall be in line with international requirements.</p>
<p>19 ДҮГЭЭР ЗҮЙЛ.СУРГАЛТЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ</p> <p>19.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь танхимын, танхимын бус, тэдгээрийн хосолсон хэлбэрээр сургалт зохион байгуулна.</p> <p>19.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь сургалт, судалгаа, туршилтын ажлын зарим хэсгийг эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрийн лаборатори, дадлагажих газрыг түшиглэн явуулж болно.</p>	<p>Article 19. Organization of training</p> <p>19.1 The higher education institution shall organize training in the form of classroom, non-classroom, and their combination.</p> <p>19.2 A higher education institution may conduct some of its training, research, and experimental activity through research institutes, industrial laboratories, and internships.</p>

<p>19.3.Дээд боловсролын хичээлийн жил нь улиралд хуваагдах бөгөөд 2-4 улиралтай байж болно. Суралцах хугацааг элсэлтийн шалгалттай уялдуулан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөгөөр зохицуулна.</p> <p>19.4.Суралцагч элссэн мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт суралцах хугацаанд бусад мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрт давхар суралцаж хос мэргэжил эзэмшиж болно.</p> <p>19.5.Дээд боловсролын сургалтын байгууллага нь ахисан түвшний сургалтын хөтөлбөрийг эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.</p> <p>19.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь төгсөгчийн мэргэжлийн хөгжлийг хангах, насан туршийн суралцахуйн тогтолцоог бүрдүүлэх ажлыг зохион байгуулна.</p> <p>19.7.Дээд боловсролын сургалтын байгууллага нь бие даан, эсхүл хамтран цахим сургалтын системийг бүрдүүлэн, сургалт зохион байгуулж болно.</p>	<p>19.3 The academic year of higher education is divided into terms, which may contain 2-4 terms. In compliance with an entrance exam, curriculum and scheduling shall regulate the study term.</p> <p>19.4. During the study time in the professional program, students can earn a double major by enrolling in other other areas of specialization.</p> <p>19.5. Higher education institutions may implement advanced study programs with research-based institutions.</p> <p>19.6. The higher education institution shall organize its activities to support the professional development of graduates and to establish a system of lifelong learning.</p> <p>19.7. The higher education institution may organize an e-learning system and organize training on its own or in collaboration with other institutions.</p>
<p>20 дугаар зүйл.Сургалтын хөтөлбөр, агуулга</p> <p>20.1.Дээд боловсролын сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>20.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь мэргэшлийн үндэсний шаталсан бүтэц, энэ хуулийн 20.1-д заасан нийтлэг шаардлагад нийцүүлэн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлнэ.</p> <p>20.3.Сургалтын хөтөлбөрийг тухайн сургалтын байгууллага боловсруулж, энэ хуулийн 11.2-т заасан хорооны дүгнэлтийг үндэслэн гүйцэтгэх удирдлага батална.</p>	<p>Article 20. Curriculum and content</p> <p>20.1. The member of the government in charge of education shall approve the general requirements for the higher education curriculum.</p> <p>20.2 Higher education institutions shall conduct training programs that adhere to the national hierarchical structure of qualifications and general requirements stated in Article 20.1 of this law.</p> <p>20.3 The curriculum is developed by the education institution and approved by the executive management based on the committee's recommendation as stated in Article 11.2 of this law.</p>

<p>20.4.Сургалтын хөтөлбөрийн агуулга нь харилцан уялдаа холбоотой ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсэгтэй байна.</p> <p>20.5.Дэд бакалавр, бакалаврын сургалтын хөтөлбөрт Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна доор дурдсан агуулгыг тусгана:</p> <p>20.5.1.ерөнхий суурь хэсэгт дээд боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны суурь мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшил;</p> <p>20.5.2.мэргэжлийн суурь хэсэгт суралцах чиглэлийн шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшүүлэх, бүтээлчээр сэтгэх, мэргэжлийн ёс зүй, эрх зүйн суурь ойлголт;</p> <p>20.5.3.мэргэших хэсэгт тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх, тухайн салбар, чиглэлийн шинжлэх ухаан, арга, технологи.</p> <p>20.6.Дээд боловсролын түвшин нь багц цагаар хэмжигдэх дэд бакалаврын, бакалаврын, магистрын, докторын зэрэгтэй байна.</p> <p>20.7.Багц цагийн хэмжээ нь дэд бакалаврын зэрэгт 90 багц цагаас доошгүй, бакалаврын зэрэгт 120 багц цагаас доошгүй, магистрын зэрэгт 30 багц цагаас доошгүй, докторын зэрэгт 60 багц цагаас доошгүй байна.</p> <p>20.8.Сургалтын агуулгыг багц цагаар тооцох, багц цагийг дүйцүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>20.9.Дээд боловсролын сургалтын байгууллага нь суралцагчийн хүсэлтээр энэ хуулийн 20.1-д заасан нийтлэг шаардлагын дагуу бакалавр-магистрын</p>	<p>20.4. The content of the curriculum is divided into three parts: general (education) core courses, professional core courses, and specialized courses</p> <p>20.5. In addition to the General Education Law, the sub- bachelor's and bachelor's curriculum shall incorporate the following content:</p> <p>20.5.1. fundamental scientific knowledge, abilities, attitudes, and maturity required for higher education in the general core courses:</p> <p>20.5.2. acquisition of fundamental scientific knowledge and abilities, creative thinking, professional ethics, and legal fundamentals in the field of professional core courses;</p> <p>20.5.3. acquisition of specific professional knowledge and abilities, science, methods, and technology of the subject, and direction in the specialized core part:</p> <p>20.6. The level of higher education is measured in credit hours and includes sub-bachelor's, bachelor's, master's, and doctor's degrees.</p> <p>20.7. The number of credit hours shall be no less than 90 for a sub- bachelor's degree, no less than 120 for a bachelor's degree, no less than 30 for a master's degree, and no less than 60 for a doctoral degree.</p> <p>20.8. The procedure for estimating the content of the curriculum in credit hours and equating credit hours shall be approved by the member of the government in charge of education.</p> <p>20.9. A higher education institution may implement a unified content curriculum with at least 150 hours for bachelor's and 90 hours for master's at the request of a</p>
---	--

<p>150-иас, магистр-докторын 90-ээс доошгүй багц цаг бүхий нэгдмэл агуулгатай хөтөлбөрийг хэрэгжүүлж болно.</p> <p>20.10.Энэ хуулийн 20.9-д заасан нэгдмэл хөтөлбөрөөр суралцсан төгсөгчид тухайн түвшин бүрийн боловсролын баримт бичгийг олгоно.</p> <p>20.11.Бакалаврын хөтөлбөрт суралцаж 90 багц цаг судалсан боловч цаашид суралцах боломжгүй болсон суралцагчид дэд бакалаврын зэрэг олгоход тавих шаардлагыг хангасан тохиолдолд тухайн боловсролын баримт бичгийг дүйцүүлэн олгож болно.</p> <p>20.12.Боловсролын ерөнхий хуулийн 3.1.4-т заасан багц цаг нь дээд боловсрол эзэмшихэд тавих шаардлага, сургалтын төлөвлөгөө, төлбөр, багшийн ажлын ачаалал зэргийг тогтоох үндэслэл болно.</p> <p>20.13.Боловсролын ерөнхий хуулийн 26.1.7-д заасан дээд боловсролын мэргэжлийн чиглэл, хөтөлбөрийн индексийн жагсаалтыг 5 жил тутам шинэчлэн батална.</p> <p>20.14.Сургалтын хөтөлбөрийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогч, төгсөгчийн төлөөллөөс бүрдсэн энэ хуулийн 11.2-т заасан Хөтөлбөрийн хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.</p> <p>20.15.Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч эзэмшсэн мэргэжлийн чиглэлээр дээд боловсролын сургалтын байгууллагад суралцахад хөтөлбөрийн агуулга, багц цаг дүйцүүлэн тооцож болно.</p>	<p>student, following the general requirement stated in Article 20.1 of this law.</p> <p>20.10. Graduates of the unified curriculum stated in Article 20.9 of this law shall be granted educational documents for each level.</p> <p>20.11 Students who have completed 90 credit hours of study in a bachelor's program and are no longer able to continue their studies can be given equivalent educational documents provided they meet the requirements for the grant of a sub-bachelor's degree.</p> <p>20.12. The credit hours stated in Article 3.1.4 of the General Law on Education form the foundation for setting higher education requirements, curriculum, tuition fees, and lecturer workload.</p> <p>20.13. Every five years, the index list of the professional sector and higher education curriculum stated in Article 26.1.7 of the General Education Law shall be updated.</p> <p>20.14. The Curriculum Committee stated in Article 11.2 of this Law, comprised of representatives from higher education institutions, professional associations, employers, and graduates, shall discuss the curriculum and give recommendations and conclusions.</p> <p>20.15. The curriculum's content and credit hours can be considered equivalent to studying at a higher education institution in the professional field obtained by a graduate of a vocational or technical educational institution.</p>
<p>21 дүгээр зүйл.Суралцагчийн үнэлгээ, төгсөлт</p>	<p>Article 21. Evaluation and Graduation of student</p>

<p>21.1.Суралцагчийн үнэлгээ нь суралцахуйн үр дүнг бататгах, бие даан суралцах үйл ажиллагаа, бүтээлч хандлагыг дэмжих, авьяас, ур чадварыг хөгжүүлж урамшуулахад чиглэнэ.</p> <p>21.2.Дээд боловсролын сургалтын байгууллагын онцлогоос хамааран суралцагчийн судалгааны ажлын үр дүн, суралцаж байгаа мэргэжлийн чиглэлээр олон улсын тэмцээн, уралдаанд гаргасан амжилтыг багц цагт тооцож болно.</p> <p>21.3.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн үнэлгээний үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>21.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчийн суралцахуйн үр дүнг үнэлэх үйл ажиллагааг энэ хуулийн 21.3-т заасан журмаар Боловсролын ерөнхий хуулийн 17.11-д заасан байгууллага, мэргэжлийн холбоо, ажил олгогчийн төлөөлөл хамтран хэрэгжүүлнэ.</p> <p>21.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид диплом олгох, хүчингүй болгох, гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагыг төгссөн төгсөгчийн дипломыг хүлээн зөвшөөрөх, бүртгэх, баталгаажуулахтай холбогдсон харилцааг Боловсролын ерөнхий хуулийн 26.1.22-т заасан журмаар зохицуулна.</p> <p>21.6.Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын дотоод журмаар зохицуулах ба докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>21.1. Student evaluation aims to improve learning outcomes by supporting independent learning activities, creative attitudes, and the development of talents and skills.</p> <p>21.2. Depending on the features of the higher education institution, the results of the student's research work, as well as success in international competitions in the field of study, may be counted in the credit hour.</p> <p>21.3.The guidelines for student evaluation of higher education institutions shall be approved by the government member in charge of education.</p> <p>21.4. The activities of evaluating the learning outcomes of students in higher education institutions shall be carried out collaboratively by the organizations, professional associations, and employer representatives stated in Article 17.11 of the General Law on Education, by the procedure stated in Article 21.3 of this Law.</p> <p>21.5.The procedure stated in Article 26.1.22 of the General Law on Education regulates the granting and revocation of diplomas to students of higher education institutions, as well as the recognition, registration, and verification of diplomas of graduates of foreign higher education institutions.</p> <p>21.6. The Master's Degree Defense Council shall be regulated by the higher education institution's internal procedure, and the Doctor's Degree Defense Council's composition shall be approved by the member of the government in charge of education.</p>
<p>ТАВДУГААР БҮЛЭГ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦ</p> <p>22 дугаар зүйл.Эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаа</p>	<p>CHAPTER FIVE RESEARCH AND INNOVATION</p> <p>Article 22.Research and Innovation Activities</p>

<p>22.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь эрдэм шинжилгээ, инновацын үйл ажиллагаа эрхэлж, гарсан үр дүнг сургалт, үйлдвэрлэлд нэвтрүүлнэ.</p> <p>22.2.Дээд боловсролын сургалтын байгууллага нь эдийн засаг, нийгмийн тэргүүлэх чиглэлээр болон ахисан түвшний хөтөлбөрийн холбогдох чиглэлээр бие дааж болон хамтарсан төсөл хэрэгжүүлнэ.</p> <p>22.3.Дээд боловсролын сургалтын байгууллага нь оюуны өмчийг бүртгүүлэх, хамгаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах технологи дамжуулах бүтцийг бий болгож, их сургууль, аж үйлдвэрийн хамтын ажиллагааг дэмжсэн тогтолцоог бүрдүүлсэн байна.</p> <p>22.4.Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их сургууль нь өөрийн үндсэн бүтцэд эрдэм шинжилгээний хүрээлэн, сургалт, судалгааны, бизнес инкубатор, технологи дамжуулах төв, гарааны компани, шинжлэх ухааны парк, технологи, инновацын кластер, туршилт үйлдвэрлэлийн болон эдгээртэй адилтгах нэгжийг бие даан, эсхүл хамтран байгуулж болно.</p> <p>22.5.Ахисан түвшний сургалтын хөтөлбөрийн хүрээнд багш, суралцагчийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг үнэлж, багшийн нэмэлт орлого олох, суралцагчийн сургалтын төлбөрийг хөнгөлөх эх үүсвэр болгон ашиглаж болно.</p> <p>22.6.Суралцагчийг эрдэм шинжилгээний ур чадвараа хөгжүүлэх, гүнзгийрүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх профессорын багт ажиллуулж, хамтран ажиллах боломжоор хангана.</p>	<p>22.1 The higher education institution shall engage in research and innovation activities and introduce the results to training and practice.</p> <p>22.2. The higher education institution shall carry out independent and collaborative projects in priority areas of economics and society, as well as relevant advanced study programs.</p> <p>22.3. The higher education institution shall establish a structure for intellectual property registration and protection, technology transfer for economic circulation, and a system that promotes collaboration between universities and industry.</p> <p>22.4. The university shall establish in its main structure academic institutes, training, and research institutes, business incubators, technology transfer centers, start-up companies, science parks, and technology and innovation centers to use intellectual and technological resources and to introduce the results of scientific and research work into practice and services. Clusters, experimental manufacturing, and similar entities can be developed individually or collaboratively.</p> <p>22.5. Within the framework of the advanced study program, the outcomes of lecturers' and students' academic and research work can be evaluated and used as a source of additional revenue for lecturers and tuition savings for students.</p> <p>22.6. To support the development of academic abilities and in-depth learning, the student will be assigned to the professor's team to implement projects and programs and will be allowed to cooperate.</p>
--	---

<p>22.7.Энэ хуулийн 22.4-т заасан нэгж нь удирдлага, санхүүгийн бие даасан үйл ажиллагаа явуулах ба холбогдох журмыг Дээд боловсролын Үндэсний зөвлөлөөс баталсан нийтлэг журам, бусад хууль тогтоомжид нийцүүлэн тухайн сургуулийн Удирдах зөвлөл батална.</p> <p>22.8.Их сургууль салбар дундын судалгааны нээлттэй лаборатори болон технологийн туршилт, зүгшрүүлэлтийн нэгдсэн сүлжээг байгуулж ажиллуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>22.7. The unit stated in Article 22.4 of this law shall carry out independent management and financial activities, and the relevant procedures shall be approved by the Board of Governors of the university by the general procedures approved by the National Council of Higher Education and other laws.</p> <p>22.8.The procedure for the university to build and maintain an open laboratory for interdisciplinary research and a unified network of technical testing and guidance shall be approved by the government member in charge of education.</p>
<p>23 дугаар зүйл.Судалгааны ёс зүй</p> <p>23.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын багш, суралцагчийн эрдэм шинжилгээний бүтээлийн нэгдсэн мэдээллийн сангийн бүртгэл, мэдээлэл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглахтай холбогдох үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн сан хариуцна.</p> <p>23.2.Судалгааны ажлын хуулбарлалтыг шалгах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>23.3.Дээд боловсролын судалгааны ёс зүйг Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Судалгааны ёс зүйн дэд хороо хариуцна.</p> <p>23.4.Энэ хуулийн 23.3-т заасан дэд хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>23.4.1.судалгааны ажилд оюуны өмч, зохиогчийн эрхийг зөрчихгүй байх, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх талаар дээд боловсролын сургалтын байгууллагад мөрдөх журам, заавар,</p>	<p>Article 23. Ethics of Research</p> <p>23.1.The Science and Technology Foundation is in charge of activities relating to the registration, information interchange, storage, protection, enrichment, and use of the unified database of research works of lecturers and students at higher education institutions.</p> <p>23.2.The technique for detecting plagiarism in research work shall be approved by the member of the Government in charge of education.</p> <p>23.3 The Research Ethics Subcommittee stated in Article 23.3 of the Law on General Education is responsible for research ethics in higher education.</p> <p>23.4.The subcommittee stated in Article 23.3 of this law shall carry out the following duties:</p> <p>23.4.1. Design, authorize and monitor the application of procedures, instructions, and recommendations for higher education institutions to prevent intellectual property and copyright infringement in research work;</p>

<p>зөвлөмж боловсруулах, батлах, хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>23.4.2. судлаачийн ёс зүйн зөрчлийн талаарх гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан хэлэлцэх, хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх.</p>	<p>23.4.2. Review and resolve complaints about researcher ethical infringement within the frame of applicable laws and regulations.</p>
<p>ЗУРГААДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА</p> <p>24 дүгээр зүйл. Дээд боловсролын удирдлага</p> <p>24.1. Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуулийн 23.1-д заасан байгууллагаас бүрдэнэ.</p> <p>24.2. Дээд боловсролын удирдлага нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>24.2.1. төрийн захиргааны бусад байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах;</p> <p>24.2.2. төрийн захиргааны бусад байгууллага болон дотоод, гадаадын байгууллага, иргэнтэй санхүүгийн дэмжлэг олгох, суралцагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хамтран ажиллах;</p> <p>24.2.3. судлаачид эрдмийн зэрэг, цол олгох нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоох.</p> <p>24.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх харьяа нэгжтэй байж болно.</p> <p>24.4. Энэ хуулийн 24.3-т заасан нэгжийг Засгийн газар байгуулж, бүтэц, ажиллах</p>	<p>CHAPTER SIX ADMINISTRATION OF HIGHER EDUCATION</p> <p>Article 24. Management of higher education</p> <p>24.1. The administration of higher education consists of organization stated in Article 23.1 of the General Education Law.</p> <p>24.2. In addition to the stipulations of the General Education Law, the higher education administration shall implement the following duties:</p> <p>24.2.1. Either with to collaborate with other state administrative organizations on the subject of training field experts;</p> <p>24.2.2. collaborate with other state administrative organizations, domestic and foreign organizations, and citizens in providing financial support and resolving social problems for students;</p> <p>24.2.3. to set general requirements and procedures for granting academic degrees and titles to researchers.</p> <p>24.3. The central state administrative organization in charge of education may have a subordinate unit to undertake asset management of state-owned higher education institutions.</p> <p>24.4. The government shall establish the unit stated in section 24.3 of this law, and the organization and operating</p>

<p>журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>procedures shall be approved by the member of the government in charge of education.</p>
<p>25 дугаар зүйл.Дээд боловсролын зөвлөл</p> <p>25.1.Дээд боловсролын салбарт Боловсролын ерөнхий хуулийн 23.3-т заасан Мэргэжлийн зөвлөл нь Дээд боловсролын зөвлөл байна.</p> <p>25.2.Дээд боловсролын зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ нь дээд боловсролын удирдлага, зохион байгуулалт, сургалт, судалгааны үйл ажиллагаа, үр дүнг хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах, оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.</p> <p>25.3.Зөвлөл нь төрийн, дээд боловсролын сургалтын байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон үйлдвэр, аж ахуйн нэгж, оюутны төлөөллөөс бүрдсэн 15 гишүүнтэй байна.</p> <p>25.4.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Боловсролын ерөнхий хуулийн 23.5-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>Article 19. Council of Higher Education</p> <p>25.1.The Higher Education Council is the Professional Council stated in Article 23.3 of the General Education Law in the sector of higher education.</p> <p>25.2. The Council of Higher Education (hereinafter referred to as "Council") is a non-staff organization tasked with higher education management, organization, training, research activities, discussion of results, making proposals and recommendations, and supporting stakeholder participation and cooperation.</p> <p>25.3. The council comprises 15 members, including representatives from the government, higher education institutions, research institutions, industry, enterprises, and students.</p> <p>25.4 By Article 23.5 of the Law on General Education, the composition and statute of the council shall be approved by the member of the government in charge of education.</p>
<p>26 дугаар зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөл</p> <p>26.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага нь Удирдах зөвлөл байна.</p> <p>26.2.Удирдах зөвлөл нь эцсийн өмчлөгч буюу үүсгэн байгуулагч, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл бүхий 15 хүний бүрэлдэхүүнтэй байна.</p>	<p>Article 26. Board of Governors of higher education</p> <p>26.1. The management of the higher education institution is the Board of Governors.</p> <p>26.2. The board of governors shall consist of 15 people who represent the ultimate owner or founder, lecturers, students, graduates, and employers of the university.</p>

<p>26.3.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл найм, багшийн төлөөлөл гурав, төгсөгч, ажил олгогчийн төлөөлөл гурав, суралцагчийн төлөөлөл нэг байна.</p> <p>26.4.Удирдах зөвлөл нь энэ хуулийн 26.8-д заасан нийтлэг дүрэмд нийцүүлэн өөрийн дүрмийг батална.</p> <p>26.5.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн энэ хуулийн 26.3-т заасан төлөөллийн оролцоог хангасан байна.</p> <p>26.6.Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллага дундын Удирдах зөвлөл байгуулж болно. Энэ тохиолдолд энэ хуулийн 26.3-т заасан төлөөллийг оролцуулсан байна.</p> <p>26.7.Энэ хуулийн 26.6-д заасан Удирдах зөвлөл байгуулах тохиолдолд зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.</p> <p>26.8.Энэ хуулийн 26.1-д заасан Удирдах зөвлөлийн даргыг сонгох, гишүүнээр ажиллах, бүрэн эрхийн хугацаа дуусгавар болгох, дарга, гишүүнийг эгүүлэн татахтай холбогдсон харилцааг зохицуулах нийтлэг дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>26.3.In the Board of Governors of state-owned higher education institutions, there are eight representatives of founders, three representatives of lecturers, three representatives of graduates and employers, and one representative of students.</p> <p>26.4.The Board of Governors shall establish its bylaw following the general rule stated in Article 26.8 of this law.</p> <p>26.5. The Board of Governors of non-state-owned higher education institutions has met the participation of representatives stated in Article 26.3 of this law.</p> <p>26.6. State-owned higher education institutions may establish a joint Board of Governors. In this term, the representative stated in Article 26.3 of this law is concerned.</p> <p>26.7.In terms of a Board of Governors established as stated in Article 26.6 of this Law, the Government shall approve the board's composition and bylaws.</p> <p>26.8. The general bylaws governing relations related to the election of the Chair of the Board of Governors, serving as a member, the expiration of the term of office, and the recall of the Chair and the member shall be approved by the member of the Government in charge of education.</p>
<p>27 дугаар зүйл.Удирдах зөвлөлийн чиг үүрэг</p> <p>27.1.Удирдах зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>27.1.1.холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тухайн дээд боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлэх урт, дунд, богино хугацааны бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, хөтөлбөрийг батлах, өөрчлөх;</p>	<p>Article 27. Duties of the Board of Governors</p> <p>27.1. The Board of Governors shall implement the following duties:</p> <p>27.1.1. Adopt or amend the long-term, medium-term, and short-term policies, plans, bylaws, regulations, and programs for the development of the institution of</p>

<p>27.1.2.дээд боловсролын сургалтын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө оруулалт, тухайн жилийн төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;</p> <p>27.1.3.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хандив, тусламж авах журам тогтоох, зарцуулалтад хяналт тавих;</p> <p>27.1.4.сургалтын төлбөр, оюутны үйлчилгээний зардал, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу төрөөс хараат бусаар тогтоох;</p> <p>27.1.5.дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;</p> <p>27.1.6.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан, сургуулийн үйл ажиллагааны тайланд хийсэн дүгнэлтийг үүсгэн байгуулагчид танилцуулах;</p> <p>27.1.7.нээлттэй сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг 5 жилийн хугацаагаар томилж, гэрээ байгуулах, хуульд заасан үндэслэлээр чөлөөлөх;</p> <p>27.1.8.гүйцэтгэх удирдлагын ажлын үр дүнг үнэлэх, гэрээ дүгнэх журмыг батлах, өөрчлөх;</p> <p>27.1.9.гүйцэтгэх удирдлагын гэрээг жил бүр дүгнэж, үр дүнд үндэслэн сунгах эсэхийг шийдвэрлэх;</p> <p>27.1.10.дээд боловсролын үндэсний зөвлөлөөс гаргасан зөвлөмж, шийдвэрийг хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах.</p>	<p>higher education in compliance with applicable laws and regulations;</p> <p>27.1.2. Approve the structure, organization, investment, and budget of the higher education institution for the current fiscal year, and supervise spending;</p> <p>27.1.3 Establish a procedure for receiving donations and support from enterprises, organizations, and citizens, as well as for monitoring spending;</p> <p>27.1.4. Independently determine the amount of tuition fees, student service expenses, and dormitory service fees using suitable procedures;</p> <p>27.1.5. Discuss, evaluate, and draw conclusions on higher education institution activity reports;</p> <p>27.1.6. Present to the founders the conclusions made in the annual report of the Board of Governors' activities and the university's activity report;</p> <p>27.1.7. Appoint the executive management of the higher education institution for 5 years based on the results of the open selection, execute a contract, and release him or her on the conditions stated by law;</p> <p>27.1.8. Approve and revise procedures for evaluating the results of executive management work performance and contracts;</p> <p>27.1.9. Annually evaluate the executive management contract and decide whether or not to extend it based on the outcomes;</p> <p>27.1.10 Implement and report on the National Council of Higher Education's recommendations and decisions.</p>
---	---

<p>27.2. Удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.</p>	<p>27.2. The Board of Governors may form and engage part-time working groups to assist in its operations.</p>
<p>28 дугаар зүйл. Эрдмийн зөвлөл</p> <p>28.1. Эрдмийн зөвлөл нь 21-ээс доошгүй гишүүнээс бүрдэх бөгөөд гишүүнээр эрдмийн зэрэг, цолтой багшийг үндсэн орон тооны нийт багш нарын төлөөллөөс сонгоно.</p> <p>28.2. Эрдмийн зөвлөл нь доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>28.2.1. сургалт, судалгааны чиглэлийг тогтоох, хэрэгжилтийн үр дүнг хэлэлцэх, дүгнэлт гаргах;</p> <p>28.2.2. дэд профессор, профессор, хүндэт цол олгох;</p> <p>28.2.3. судалгааны төсөл болон ахисан түвшний сургалт судалгааны үр дүнг хэлэлцэх, дүгнэх.</p> <p>28.3. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон бусад харилцааг тухайн дээд боловсролын сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагааны журмаар зохицуулна.</p> <p>28.4. Эрдмийн зөвлөл нь сургалт, эрдэм шинжилгээний бодлого, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл байна.</p>	<p>Article 28. Academic senate</p> <p>28.1. The Academic Senate shall consist of at least 21 members and a lecturer with an academic degree shall be elected as a member from full-time lecturers.</p> <p>28.2. The Academic Senate shall implement the following duties:</p> <p>28.2.1. Define the direction of study and research, to discuss implementation outcomes, and to draw conclusions;</p> <p>28.2.2. Grant honorary degrees, associate professor, and professor;</p> <p>28.2.3 Discuss and evaluate the outcomes of research projects and advanced study programs.</p> <p>28.3. Other activities related to the academic senate's operations are regulated by the academic senate's procedure at the higher education institution.</p> <p>28.4 The Academic Senate is a part-time council that decides on training and academic policies and activities.</p>
<p>29 дүгээр зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага</p> <p>29.1. Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлага нь дээд сургууль, коллежид захирал /цаашид "захирал" гэх/, их сургуульд ректор /цаашид "ректор" гэх/ байна.</p>	<p>Article 29. Executive management of Higher education institution</p> <p>29.1. The executive management /hereinafter referred to as "director" in universities and colleges, and the rector /hereinafter referred to as "rector" in universities, is the executive</p>

<p>29.2.Захирал, ректорыг гэрээний биелэлт, үр дүнд үндэслэн нэг удаа улируулан томилж болно.</p> <p>29.3.Цэрэг, цагдаагийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг хууль зүй, дотоод хэргийн болон батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.</p> <p>29.4.Төрийн болон орон нутгийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэх удирдлагыг сонгон шалгаруулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p>	<p>management of a higher education institution.</p> <p>29.2 The director and rector may be elected as Rector two times in a row depending on contract outcomes and performance.</p> <p>29.3. The executive management of military and police higher education institutions shall be appointed by the government member in charge of legal affairs, internal affairs, and defense, and shall be dismissed on the grounds stated by law.</p> <p>29.4 The procedure for appointing the executive management of state and local-owned higher education institutions shall be approved by the government member in charge of education.</p>
<p>30 дугаар зүйл.Гүйцэтгэх удирдлагын чиг үүрэг</p> <p>30.1.Гүйцэтгэх удирдлага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>30.1.1.дээд боловсролын сургалтын байгууллагыг улсын хөгжлийн бодлоготой уялдуулан хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, чиглэл, хөтөлбөрийг санаачлан Удирдах зөвлөлөөр батлуулж, хэрэгжилтийг хангах;</p> <p>30.1.2.гадаад, дотоод хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, хамтарсан сургалт, хөтөлбөр, эрдэм шинжилгээ, судалгааны төсөл хэрэгжүүлэх асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах, хэрэгжилтийг хангах;</p> <p>30.1.3.байгууллагын стратеги төлөвлөгөөний гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, зорилтот түвшний хэрэгжилтийн чанар, үр дүнг бүрэн хариуцах;</p> <p>30.1.4.санхүүжилт, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бүрдүүлж, санхүү, төсвийг үр дүнтэй төлөвлөж зарцуулах;</p>	<p>Article 30. Duties of Executive Management</p> <p>30.1. Executive management shall implement the following duties:</p> <p>30.1.1. Develop strategic plans, orientations, and programs for the expansion of higher education institutions in by national development strategy, obtain Board of Governor’s approval for them, and oversee their implementation;</p> <p>30.1.2. Establish agreements on external and internal cooperation and partnership development, implement joint training, program, research and research project, and ensure their implementation;</p> <p>30.1.3. Be fully responsible for the quality and results of the organization's performance indicators and target level;</p> <p>30.1.4. Provide funding and investment sources, as well as manage and spend finances and budgets effectively;</p>

<p>30.1.5.сургуулийн хөгжлийг дэмжихэд үр нөлөөтэй, хөгжихүйн болон чадахуйн /мерит/ зарчмыг хангасан засаглал, менежментийн тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх;</p> <p>30.1.6.хүний нөөцийг чадавхжуулах, өндөр мэдлэг ур чадвартай мэргэжилтнийг татан ажиллуулах нөхцөлийг бүрдүүлсэн хүний нөөцийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлж, багш, ажилтны нийгмийн баталгааг хангах;</p> <p>30.1.7.дээд боловсролын сургалтын байгууллагын чанарын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;</p> <p>30.1.8.багш, судлаач, эрдэм шинжилгээний ажилтан болон бусад ажилтны орон тоо, цалингийн сүлжээг баталж, сонгон шалгаруулалтыг чадахуйн /мерит/ болон хөгжихүйн зарчимд үндэслэн явуулж, томилох;</p> <p>30.1.9.гүйцэтгэх удирдлагын чиг үүрэгтэй холбогдсон бусад харилцааг сургуулийн дүрмээр зохицуулна.</p>	<p>30.1.5. Establish and carry out a governance and management system that is effective in supporting university development and adheres to the development and ability /merit/ principles;</p> <p>30.1.6. Effectively implement a human resources policy that supports the empowerment of human resources and the employment of highly qualified and talented specialists, as well as providing social security for lecturers and employees;</p> <p>30.1.7.Implement quality management activities in higher education institutions;</p> <p>30.1.8. Approve the positions and salary networks of lecturers, researchers, academic staff, and other employees, as well as carry out and appoint selections based on ability/merit/ and development principles;</p> <p>30.1.9. Other activities related to the executive management duties shall be regulated by the University Statute.</p>
<p>31 дүгээр зүйл.Дээд боловсролын сургалтын байгууллагын чиг үүрэг</p> <p>31.1.Дээд боловсролын сургалтын байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>31.1.1.дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновац, сургуулийн үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий этгээдийн баталсан бодлого, стратеги төлөвлөгөө, дүрэм, журмыг чанартай хэрэгжүүлэх, тайлагнах;</p>	<p>Article 31. Higher education institution’s duties</p> <p>31.1. Higher education institutions are responsible for the following duties:</p> <p>31.1.1. Ensure the high-quality implementation and reporting of policies, strategic plans, bylaws, and regulations approved by authorized individuals in higher education, science, technology, innovation, and university operations;</p>

<p>31.1.2.сургуулийн дотоод үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг батлан хэрэгжүүлэх;</p> <p>31.1.3.сургалтын хөтөлбөр, агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэлийг тодорхойлж, чанартай хэрэгжүүлэх;</p> <p>31.1.4.зөвлөх үйлчилгээ, эрдэм шинжилгээ, судалгаа, хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, оролцох;</p> <p>31.1.5.элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг зохих журмын дагуу зохион байгуулах;</p> <p>31.1.6.тусгай хэрэгцээ шаардлагатай суралцагчийг дэмжих хөтөлбөр баталж, шаардагдах орчин нөхцөлийг бүрдүүлэх;</p> <p>31.1.7.багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, технологийн судалгаа хийх;</p> <p>31.1.8.сургуулийн үйл ажиллагаа, сургалтад цахим технологи нэвтрүүлэх;</p> <p>31.1.9.гадаад, дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, шинжлэх ухааны парк, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр байгуулах;</p> <p>31.1.10.багш, ажилтан, суралцагчийг соён гэгээрүүлэх, олон нийтийн болон хүмүүнлэгийн чиглэлийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр батлан хэрэгжүүлэх;</p> <p>31.1.11.багш, ажилтан, суралцагчийн эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;</p>	<p>31.1.2. Establish and implement statutes and regulations regulating internal university activities;</p> <p>31.1.3. Define the aims and directions of curricula, content, methods, forms, research, and experimental activities, and ensure their high quality of implementation;</p> <p>31.1.4. Conduct and participate in consulting, research, and investment projects;</p> <p>31.1.5 Organize admission and graduation activities in accordance with specified regulations;</p> <p>31.1.6. Approve and implement programs to support students with exceptional needs;</p> <p>31.1.7. Provide training and retraining for lecturers and academic staff, and conduct technical research related to their activities;</p> <p>31.1.8. Implement electronic technology in educational activities and training;</p> <p>31.1.9. Enter into agreements and negotiations on matters of authority with international and domestic educational and scientific organizations, science parks, and other individuals;</p> <p>31.1.10 Approve and implement a program for protecting the health of lecturers, employees, and students, reduce risks, and promote public physical activity and sports participation.;</p> <p>31.1.11 According to the university statute, the educational institution shall provide scholarships and tuition fee discounts to students who have successfully studied and engaged in</p>
---	---

<p>31.1.12.амжилттай суралцаж, олон нийтийн болон хүмүүнлэгийн бүтээлч ажил гүйцэтгэсэн суралцагчид тухайн сургалтын байгууллага тэтгэлэг олгох, төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх асуудлыг сургуулийн дүрэмд тусган хэрэгжүүлэх;</p> <p>31.1.13.аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөр, амьжиргааны зардлын болон эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дэмжлэг үзүүлэх;</p> <p>31.1.14.статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх.</p> <p>31.2.Дээд боловсролын сургалтын байгууллага доор дурдсан хамтын ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй:</p> <p>31.2.1.олон улсад өрсөлдөх чадвартай багшлах хүний нөөцийг бэлтгэх, дэмжих;</p> <p>31.2.2.онцгой авьяастай суралцагчийг дэмжих, авьяасыг хөгжүүлэх хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэх;</p> <p>31.2.3.дээд боловсролын сургалтын байгууллага хооронд харилцан тохиролцсон бусад хэлбэр.</p>	<p>creative public and humanitarian activities.;</p> <p>31.1.12 According to the university statute, the educational institution shall provide scholarships and tuition fee discounts to students who have successfully studied and engaged in creative public and humanitarian activities.</p> <p>31.1.13. Sign contracts with organizations or companies to grant scholarships, cover tuition fees, living costs, and provide academic and research work support to students who have excelled in training and academic work.</p> <p>31.1.14 Submit statistical and other essential information to relevant authorities within specified deadlines.</p> <p>31.2. The higher education institution is obligated to engage in the following cooperation:</p> <p>31.2.1. Prepare and support internationally competitive teaching human resources;</p> <p>31.2.2. Implementing a cooperative program to support and develop students with outstanding skills;</p> <p>31.2.3. Explore other formats mutually agreed upon by higher education institutions.</p>
<p>ДОЛДУГААР БҮЛЭГ ДЭЭД БОЛОВСРОЛЫН САНХҮҮЖИЛТ</p> <p>32 дугаар зүйл.Дээд боловсролын санхүүжилт</p> <p>32.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт нь Боловсролын</p>	<p>CHAPTER SEVEN FUNDING OF THE HIGHER EDUCATION</p> <p>Article 32. Funding of higher education</p> <p>32.1. In addition to the provisions of the General Law on Education, the following</p>

<p>ерөнхий хуульд зааснаас гадна дараах эх үүсвэрээс бүрдэнэ:</p> <p>32.1.1.үүсгэн байгуулагчаас шилжүүлсэн хөрөнгө;</p> <p>32.1.2.олон улсын байгууллага, хөрөнгө оруулалтын сангаас олгох хөгжлийн тусламж, хандивын хөрөнгө;</p> <p>32.1.3.Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;</p> <p>32.1.4.дээд боловсролын сургалтын байгууллагын дэргэд байгуулсан гарааны компанийн үйл ажиллагаанаас орсон орлого;</p> <p>32.1.5.технологи дамжуулалт, патент, ашигтай загвар, роялти, зөвлөх үйлчилгээнээс олсон орлого, гэрээт ажил, үйлчилгээ, түрээс, аж ахуйн үйл ажиллагаанаас орсон орлого;</p> <p>32.1.6.сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орох орлого;</p> <p>32.1.7.хүүгийн орлого;</p> <p>32.1.8.байгууллагын болон судалгааны грант;</p> <p>32.1.9.өрсөлдөөнт төсөл;</p> <p>32.1.10.их сургуулийн эмнэлгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнээс олсон орлого;</p> <p>32.1.11.хөрөнгө оруулалтын зээл;</p> <p>32.1.12.орон нутгийн төсвийн дэмжлэг;</p> <p>32.1.13.хуульд заасан бусад эх үүсвэр.</p> <p>32.2.Дээд боловсролын сургалтын байгууллагад улсын төсвөөс дараах дэмжлэг үзүүлнэ:</p>	<p>sources contribute to the funding of higher education institutions:</p> <p>32.1.1. Assets transferred by the founder;</p> <p>32.1.2 Development aid and donation funds from international organizations and investment funds;</p> <p>32.1.3. Fund projects and programs in compliance with intergovernmental agreements;</p> <p>32.1.4. Revenue from the operation of a start-up company founded at a higher education institution;</p> <p>32.1.5. Revenue from technology transfer, patents, utility models, royalties, consulting services, contract labor, services, rent, income from business-related activities;</p> <p>32.1.6. Revenue generated from issuing and using the University's branded products and registered trademarks through their sale;</p> <p>32.1.7. Interest income;</p> <p>32.1.8. Grants from institutional and research sources;</p> <p>32.1.9. Competitive project;</p> <p>32.1.10. Revenue generated from university hospital healthcare services;</p> <p>32.1.11. Investment loan;</p> <p>32.1.12. a local project support;</p> <p>32.1.13. other sources stated in the law.</p> <p>32.2. The state budget shall provide the following support to the higher education institution:</p>
---	--

<p>32.2.1.тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагчид олгох сургалт, судалгааны тэтгэлэг;</p> <p>32.2.2.улс орны нийгэм, эдийн засагт үзүүлэх ач холбогдол бүхий Засгийн газрын захиалгат судалгаа шинжилгээ, дэвшилтэт технологи дамжуулалт болон инновацын үйл ажиллагааны зардал;</p> <p>32.2.3.төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын эзэмшиж, ашиглаж байгаа хөрөнгийн төрийн өмчийн тогтмол зардал.</p> <p>32.4.Дээд боловсролын сургалтын байгууллагын эндаументын сангийн бүрдүүлэлт болон зарцуулалттай холбогдох нийтлэг журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.</p> <p>32.5.Энэ хуулийн 6.6-д заасан дээд боловсролын сургалтын байгууллага нь хуулиар зөвшөөрсөн нийтлэг санхүүжилтийн эх үүсвэрээс гадна үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэл, онцлогоос хамаарч улсын төсвийн нэмэлт санхүүжилтийн эх үүсвэртэй байж болох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.</p> <p>32.6.Аймаг, нийслэлийн удирдлага дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид хуульд заасан санхүүгийн дэмжлэг олгож болох бөгөөд санхүүгийн дэмжлэгийн төрөл, хэмжээ, олгох нөхцөл, журмыг тухайн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтоож, тухайн жилийн төсөвтөө тусган санхүүжүүлнэ.</p> <p>32.7.Энэ хуулийн 32.2-т заасан зардлыг гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлнэ.</p>	<p>32.2.1. grants for training and research for students in high-demand professional fields</p> <p>32.2.2. Fund government-ordered research and analysis, advanced technology transfer, and other significant innovative activities benefiting the country's society and economy;</p> <p>32.2.3 Fixed expenses related to state-owned property owned and used by state-owned higher education institutions.</p> <p>32.4 The general procedure for the formation and expenditure of the higher education institution's Education Endowment fund shall be approved by the member of the Government in charge of education.</p> <p>32.5. In addition to the standard funding sources authorized by law, the higher education institution stated in Article 6.6 of this law may receive additional funding from the state budget based on the operation's results, performance, and characteristics, and the financing procedure shall be approved by the Government.</p> <p>32.6. Province and capital administrations may provide financial support to students of higher education institutions as stated by law, and the type, amount, conditions, and procedures for providing financial support shall be determined by the Representative Meeting of Citizens of that province and capital city, and the funding for this support shall be allocated from the current year's budget.</p> <p>32.7. The expenses stated in Article 32.2 of this law shall be funded based on performance and outcomes.</p>
--	--

<p>32.8.Энэ хуулийн 32.2-т заасан зардлыг санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.</p> <p>33 дугаар зүйл.Бие даасан санхүүгийн үйл ажиллагаа</p> <p>33.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь санхүү, төсвийн хувьд бие даасан байдлаа хадгалах талаар дараах үйл ажиллагаа эрхэлнэ:</p> <p>33.1.1.оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт, судалгааны бизнес инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн иж бүрдэл тогтолцоогоор байгуулан ажиллуулах;</p> <p>33.1.2.хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх, сургалтын материаллаг орчныг сайжруулах зорилгоор зээл авах;</p> <p>33.1.3.сургуулийн нэрийн бүтээгдэхүүн болон бүртгэгдсэн барааны тэмдэг гаргах, бусдад ашиглуулах, түүний борлуулалтаас орлого олох;</p> <p>33.1.4.дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор мөнгөн хөрөнгийн удирдлагыг оновчтой зохион байгуулах.</p>	<p>32.8. The procedures for funding the expenses stated in Article 32.2 of this Law shall be approved by the Government.</p> <p>Article 33. Independent financial activity</p> <p>33.1. To maintain its financial and budget independence, the institution of higher education shall engage in the following activities:</p> <p>33.1.1. Using intellectual and technological resources, integrating scientific and research findings into production and services, establishing and operating training and research business incubators and technology transfer centers as part of its main structure, either individually or as a set of production systems;</p> <p>33.1.2. Obtain loans to carry out investment projects and enhance the material environment of education;</p> <p>33.1.3. Issue and utilize the university's registered trademarks, and generate income from their sale;</p> <p>33.1.4. optimize cash resource management to support the main operations of higher education institutions.</p>
<p>НАЙМДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ,</p> <p>34 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага</p> <p>34.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.</p> <p>34.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн</p>	<p>CHAPTER EIGHT OTHER,</p> <p>Article 34: Violators' Responsibilities</p> <p>34.1.If a violation of this law does not constitute a criminal, the civil service and labor laws shall be applied.</p> <p>34.2. An individual or legal entity who violates this law shall be held responsible</p>

тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.	in accordance with the Criminal Code or the Law on Violations.
--	--